



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/46

Алтрага

Нөөц хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаал, 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 3.2, 4.1 дүгээр хэсэг, аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/79 дүгээр захирамж, сумын Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 2024 оны 07 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тэжээл татах тээврийн зардал, зам даваа нээх, нохой устгах, сэг зэмийн шатахууны зардал, эмч нарыг алдаршуулах зардал, хил хамгаалах туслах хүчний салбар зөвлөлийн хуралдааны үйл ажиллагааны зардал зэрэг ажлуудад зарцуулагдах шатахуун болон холбогдох зардлуудын 3,779,100 (гурван сая долоон зуун далан есөн мянга нэг зуу) төгрөгийг Засаг даргын нөөцөөс гаргасугай.

2.Дээрх төлбөр тооцоог барагдуулж, гүйлгээ хийхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Э.Ариунаа)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Чимэдцэрэн)-д даалгасугай.

ДАРГА



Г.ОДСЭР